

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ ТОВЧ ТАЙЛАН

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хамт олны хуралдаанаар албан хаагчдын санал асуулгын дүнг үндэслэн байгууллагын Ёс зүйн зөвлөлийг байгуулж ажиллаж байна.

Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс харьяа сумд, агентлаг, байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн ажлыг шалгаж, зөвлөн туслах, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг тухайн байгууллагаас гаргасан хүсэлт тухай бүрт зохион байгуулж байна. Улирал тутам зохион байгуулагдаж байгаа удирдах ажилтны цугларалтанд ёс зүйн зөрчилтэй холбоотой хууль дүрэм журмын шинэчлэлт, өөрчлөлтийн талаар танилцуулав.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Эрх зүйн хөтөч” өдөрлөгийг Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх, Алаг-Эрдэнэ,



Хатгал, Ханх

суманд зохион байгуулж төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэд байгууллагаас санал хүсэлт хүлээн авах ажлыг зохион байгуулсан.

Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажлын бүтээмжийг дээшлүүлэх, шинэ санаа, оновчтой шийдлийг нэвтрүүлэх зорилгоор “Санаа шийдэл” саналын хайрцагаар аймгийн ЗДТГ-ын албан хаагчдаас 7 хоног бүр харьяа хэлтэс, нэгжээр

аялуулж санал авч байна. Саналын хайрцагийг аймгийн Засаг дарга нээж танилцан холбогдох шийдвэрийг гарган ажилласан.

Байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хөдөө аж ахуйн газарт хийсэн бол нийт сумдын ЗДТГ-ын дарга нарт зөвлөлийн даргын зүгээс “Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой маргаан хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр зохион байгуулсан байна. Мөн Цагааннуур сумын төрийн албан хаагчдын зөвөлгөөнд төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчдын санал, хүсэлтийг авлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 33 тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” шинэчлэгдсэнтэй холбоотойгоор хууль эрх зүйн орчин, эрх хэмжээ өөрчлөгдөж өмнө нь ажиллаж байсан аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн Ёс зүйн хороо нь аймгийн ЗДТГ-ын ёс зүйн зөвлөл болсон тул 2019 онд зөвхөн харьяа байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан талаар иргэдийн гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр, холбогдох байгууллагын хяналт шалгалт, удирдах ажилтны шийдвэрээр илэрсэн зүйлгүй болно. Өөрөөр хэлбэл 2019 онд аймгийн ЗДТГ-ын албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийг тогтоосон зөвлөлийн дүгнэлт шийдвэр гаргасан тохиолдол байхгүй.

Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчдын гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдож байгаа талаар мэдээллийг аймгийн цагдаагийн газраас 14 хоног тутамд авч ажил олгогчдод хүргэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Ирүүлсэн мэдээлэлд шинжилгээ хийж зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийн шалтгааныг тогтоож, хариу арга хэмжээ авах талаар зөвлөмж боловсруулан хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

ТОВЧ ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.ГАНДЭЛГЭР